



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/509

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан БУАХААГ/20240102067 урилгын дугаартай Хатуу хог хаягдлыг ангилан ялгах, боловсруулах зорилгоор хог түрж булах техник худалдан авах (Бугат, Тэшиг, Баян-Агт, Орхон) нийлүүлэх нийлүүлэгчээр шалгарсан “Монтех дистрибьюш” ХХК-тай 319 913 000 (гурван зуун арван есөн сая есөн зуун арван гурван мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр)-д олгосугай.

2. Ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр)-д олгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Монтех дистрибьюш” ХХК-ийн захирал (Б.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

5. Хөрөнгийг данс бүртгэлд тусгаж ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр)-д даалгасугай


ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

6324010670

Аймгийн Засаг даргын 2024 оны
D.7 дугаар сарын 17-ны өдрийн
A/509 дугаар захирамжийн хавсралт



Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь байхаар зааж өгнө.	А.Гантөмөр
3	Баталгаат хугацаа	1 жил	А.Гантөмөр